**НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2014 оны 09 сарын 04 өдөр Дугаар А/43 Улаанбаатар хот

"Спортлог Улаанбаатар" өдөрлөгийн ажлын хэсэг зохион байгуулах тухай

Монгол Улсын "Биеийн тамир, спортын тухай" хууль, Засгийн газрын 2009 оны 05, 2014 оны 43 дугаар тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн 2014 оны зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэл Улаанбаатар хот байгуулагдсаны 375 жилийн ойд зориулсан "Спортлог Улаанбаатар" бүх нийтийн өдөрлөгийг 2014 оны 10 дугаар сарын 05-ны өдөр Эзэн Чингисийн талбай дээр зохион байгуулсугай.

2. "Спортлог Улаанбаатар" бүх нийтийн өдөрлөгийг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар батлсугай.

3. "Спортлог Улаанбаатар" бүх нийтийн өдөрлөгийн урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж хөтөлбөрийн дагуу зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг ахлах мэргэжилтэн А.Болдмаад үүрэг болгосугай.

ДАРГА Ж.ГАНБОЛД

Tushaal 2014

1150500101